

**Ачаа тээврийн үйлчилгээний баталгаажуулалтын схемийн шаардлагын дагуу  
өөрийгөө үнэлэх үнэлгээний хуудас**




№	Шалгуур үзүүлэлтүүд	Үйлчилгээний ангилал		Шаардлага хангасан байдал		Тайлбар
		Улс хоорондын тээвэрлэлт	Дотоодын ачаа тээвэрлэлт	Тийм	Үгүй	
<b>АЧАА ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ШААРДЛАГА</b>						
1	Улсын бүртгэлд бүртгүүлж улсын бүртгэлийн гэрчилгээ авсан байх	✓	✓			
2	Ачаа тээврийн үйл ажиллагааг Иргэний хууль, Автотээврийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн тээвэрлэлтийн гэрээний үндсэн дээр эрхэлнэ.	✓	✓			
3	Ачаа илгээгч, ачаа хүлээн авагчид өөрийн хүчин чадал, тээвэрлэлтийн үнэ хөлс зэрэг автотээврийн үйлчилгээтэй холбогдсон үнэн зөв мэдээлэл өгөх;	✓	✓			
4	Тээвэрлэлттэй холбоотой баримт бичгийн бүрдүүлэлтийг хийж, анхан шатны бүртгэл хөтлөх;	✓	✓			
5	Тээвэрлэлтийн талаарх мэдээллээ тухайн орон нутгийн, эсхүл тээвэрлэлтийн гэрээ байгуулсан автотээврийн байгууллагад сар бүр үнэн зөв гаргаж өгнө. Мэдээлэл нь цахим болон бусад хэлбэрээр байж болно	✓	✓			
6	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заавар журам баталж, мөрдүүлсэн байна.	✓	✓			
7	Урьдчилсан ба хугацаат үзлэгт ажилтныг хамруулна.	✓	✓			
8	Ажилд гарахын өмнө эмчийн үзлэгт заавал хамрагдаж замын хуудаст зохих тэмдэглэгээг хийлгэх;	✓	✓			
9	Тухайн байгууллагын ХАБЭА хариуцсан албан тушаалтан нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан байна.	✓	✓			

















10	Жолоочийн хөдөлмөр, амралтын горимыг байгууллагын дотоод дүрэм, журам, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн баталж хэрэгжүүлэх.					
11	Өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам” баталж мөрдүүлсэн байна.					
12	Улс хоорондын байнгын ачаа тээвэр, аюултай ачаа тээвэрлэхдээ автотээврийн хэрэгсэл нь байршил тогтоох хяналтын төхөөрөмжөөр тоноглогдож, тээврийн зохион байгуулалт, зохицуулалтын үйл ажиллагаа хариуцан ажиллаж буй байгууллагын хөдөлгөөний удирдлага хяналтын төвд холбогдсон байна.					
13	Дотоодын ачаа тээвэрлэлтийг үйл ажиллагаа нь ачаа тээврийн үйлчилгээний чиглэлээр мэргэшсэн, автотээврийн асуудал эрхэлсэн холбогдох байгууллагын бүртгэл, мэдээллийн санд бүртгэлтэй тээвэрлэгч гүйцэтгэнэ.					
14	Хот хоорондын ачаа тээврийн үйлчилгээ нь нэгдсэн мэдээллийн сан, сүлжээг/ачаа тээврийн агент/-ээр дамжин захиалгын дагуу явагдана.					
15	Тээвэрлэгч, зуучлагч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь тээврийн хэрэгсэл замд эвдэрч саатсан тохиолдолд тухайн ачааг зохих газар нь саадгүй хүргэх арга хэмжээг урьдчилан хангасан байх ба шаардагдах арга хэмжээг яаралтай зохион байгуулах чадвартай техникийн болон боловсон хүчний нөөцтэй байна.					
16	Улс хоорондын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгслийн болон жолоочийн гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагыг заавал даатгуулсан байна.					
17	Эрхлэх ажил, үйлчилгээ нь хүрээлэн байгаа орчин, оршин суугчдад сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй, галын болон аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, хөдөлмөрийн эрүүл ахуй, тав тухтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлсэн байх.					
18	Аюултай шингэн хог хаягдлыг зориулалтын бат бөх, аюултай хог хаягдалтайгаа урвалд ордоггүй саванд түр хадгалж аюултай хог хаягдал цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах зөвшөөрөл бүхий газартай гэрээ байгуулан хүлээлгэн өгч ажиллана.					

19	Бусад аюултай хог хаягдал, тэдгээрийн сав, баглаа боодлыг төрөлжүүлэн түр хадгалж аюултай хог хаягдал цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах зөвшөөрөл бүхий газартай гэрээ байгуулан хүлээлгэн өгнө.					
<b>МАШИН МЕХАНИЗМ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД ТАВИХ ШААРДЛАГА</b>						
20	Ачаа тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангасан зориулалтын тээврийн хэрэгсэлтэй байна.					
21	Автотээврийн хэрэгслийг жилд нэг удаа тогтсон хугацаанд үзлэгт хамруулна.					
22	Техникийн улирлын үйлчилгээний болон гүнзгийрүүлсэн оношлогоо үйлчилгээний хугацааг гүйлтийн үечлэлээр (км)-ээр тогтоох бөгөөд үйлдвэрлэгчийн тогтоосон хугацаа, үечлэл (км)-ыг баримжаа болгон автомашин эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага, иргэд тээврийн хэрэгслийн ашиглалтын нөхцөлтэй уялдуулан өөрсдөө тогтоож мөрдсөн байна.					
23	Автотээврийн хэрэгсэл нь хувийн хэрэг болон техник ашиглалтын дэвтэртэй байна.					
24	Техник ашиглалтын дэвтэрт автотээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засвар хийсэн тухай болон тухайн засвар, үйлчилгээгээр зарцуулсан сэлбэг зэргийг засвар үйлчилгээ хийсэн аж ахуйн нэгж, байгууллага хариуцан тэмдэглэнэ.					
25	Техник ашиглалтын дэвтэрт нийт явсан гүйлт, зарцуулсан шатахуун, гүйцэтгэсэн ажлын хэмжээ зэрэг техник ашиглалтын үзүүлэлтийг тухайн автотээврийн хэрэгслийн эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага хариуцан тэмдэглэл хийнэ.  Ачаа тээврийн хэрэгсэл нь ачааг бүрэн бүтэн, гэмтэлгүй тээвэрлэх боломжийг бүрдүүлсэн, байгаль, цаг уурын үзэгдэл, түүний (бороо, цас, тоос )					
26	Хүйтний улиралд хөдөлгүүрийг (автономи) урьдчилан халаагч хэрэгслээр, бүхээгийг дулаацуулагч хэрэгслээр тус тус тоноглон байна.					

27	Тээврийн хэрэгслүүд өөр хоорондоо болон төвтэй холбогдох сансрын болон цахим сүлжээний холбооны хэрэгслээр хангагдсан байх.	✓				
28	Ачаа тээврийн хэрэгсэл нь ачааг бүрэн бүтэн, гэмтэлгүй тээвэрлэх боломжийг бүрдүүлсэн, байгаль цаг уурын үзэгдэл, түүний (бороо, цас, тоос, шороо) нөлөөллөөс хамгаалахаар сайтар битүүмжлэгдсэн байна.	✓	✓			
29	Аж ахуй нэгж байгууллага нь өөрийн хэмжих хэрэгслийг шалгалт тохируулгад хамруулах	✓	✓			
30	Өргөх, зөөх, тээвэрлэх хэрэгсэлд мэргэжлийн байгууллагаар техникийн магадалгаа хийлгэж, зохих зөвшөөрлийг авсан байна.	✓	✓			
31	Суурин болон зөөврийн тоноглол нэг бүрд техник ашиглалтын бүртгэлийн дэвтэртэй байна.	✓	✓			
32	Тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, тохируулгыг техникийн баримт бичигт заасан хугацаанд тогтмол хийж, техникийн ашиглалтын паспортад тэмдэглэдэг.	✓	✓			
33	Ажлын байранд хийгдэх техникийн оношлогоо үйлчилгээ, засварын ажлын төрөл бүрээр ажлын дэс дарааллыг тогтоосон технологийн карттай байна эсвэл үйлдвэрлэгчээс тогтоосон техникийн норм, дүрэм, зааварчилгааг мөрдлөг болгоно	✓	✓			
<b>БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИД ТАВИХ ШААРДЛАГА</b>						
34	Засварын байр нь технологийн карт эсвэл үйлдвэрлэгчээс тогтоосон техникийн норм, дүрэмд тусгасан тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр иж бүрэн тоноглогдсон байна.	✓	✓			
35	Барилга, байгууламжийг эзэмших, ашиглахтай холбогдсон баримт бичгийг зохих ёсоор бүрдүүлсэн байна.	✓	✓			
36	Техникийн оношлогоо үйлчилгээ, засварын байр хөдөлгүүрийн ажилласан хийг зайлуулах агааржуулалтын системтэй байна.	✓	✓			
37	Техникийн оношлогоо үйлчилгээ, засварын байр гэрэлтүүлэх системтэй байна.	✓	✓			

















38	Техникийн оношлогоо үйлчилгээ, засварын байр дулаацуулах системтэй байна.	✓	✓			
39	Эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагын дагуу цэвэр, бохир усны системд холбогдсон эсвэл тусгай байгууламжтай байна.	✓	✓			
40	Ажилчдын хувцас солих болон амрах байр, бие засах, гар угаах газар, үйлчлүүлэгчийн хүлээлгийн өрөөтэй байна.	✓	✓			
41	Өөрийн эсвэл гэрээт гараж, зогсоолтой байна.	✓	✓			
42	Авто зогсоол, гараж нь гэрэлтүүлэгтэй.	✓	✓			
43	Авто зогсоол, гараж нь дулаацуулах системтэй.	✓	✓			
44	Авто зогсоол нь галын аюулгүйн багаж хэрэгслээр бүрэн хангагдсан, тэдгээр нь хэвийн ажиллагаатай.	✓	✓			
45	Битүү зогсоол нь харуул хамгаалалт, дохиолол, телекамер, галын аюулгүйн дохиололтой байна.	✓	✓			
46	Зогсоолд тээврийн хэрэгсэл байрлах байрлал, хөдөлгөөний чиглэл болон галын аюулын үеийн хөдөлгөөний бүдүүвч зургийг орох, гарах хаалганд ил байрлуулсан	✓	✓			
47	Автотээврийн хэрэгсэл байрлах зогсоолын байрлалыг цагаан зураасаар, аюулгүйн тэмдэглэгээг шар зураасаар тэмдэглэсэн.	✓	✓			
<b>АЖИЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА</b>						
48	Ажил албан тушаалын жагсаалт баталж мөрдүүлсэн байна.	✓	✓			
49	Ажилтнаар ажлын байрны тодорхойлолтод заасан үүргийг гүйцэтгүүлдэг.	✓	✓			
50	Хөдөлмөрийн гэрээг ажилтан бүртэй бүрэн байгуулсан байна.	✓	✓			
51	Засвар, үйлчилгээ хариуцсан инженер нь автотээврийн салбарын механик-инженерийн мэргэжилтэй байна.	✓	✓			











52	Засвар, үйлчилгээ хариуцсан инженер нь автотээврийн хэрэгслийн техникийн байдлыг оношлох, засвар үйлчилгээ хийх талаар өндөр ур чадвар, дадлага туршлагатай байна.					
53	Засвар, үйлчилгээ хариуцсан инженер нь засвар үйлчилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, технологи ажиллагаа, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга техникийг мэдсэн байна.					
54	Шалгах механикч нь автотээврийн механикч мэргэжилтэй байна.					
55	Шалгах механикч нь тухайн чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.					
56	Шалгах механикч нь тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагадаа тулгуурлан шалгаж, шаардлагатай баримт бичгийн бүрдэл, жолооч ажилд гарахад нөлөөлөх сөрөг хүчин зүйлгүй болохыг магадлаж үйлчилгээнд гаргах үүргийг хүлээнэ.					
57	Шалгах механикч нь үйлчилгээнээс буцаж ирэхэд тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, эвдрэл гэмтэл илэрсэн тохиолдолд засвар хийлгэх, тогтоосон хугацаанд нь техникийн үйлчилгээ хийлгэх, засвар үйлчилгээний чанарт хяналт тавина.					
58	Засварын цехийн механикч, техникч нь “автотээврийн техникч-механикч” мэргэжилтэй, тухайн чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.					
59	Техникч, механикч нь засвар үйлчилгээний газрын байр, тоног төхөөрөмж, дулаан, цахилгаан хангамжийн хэвийн ажиллагаанд хяналт тавьж, автотээврийн хэрэгслийн засвар, техникийн үйлчилгээний үйл ажиллагааг зохион байгуулж, засварчдад ажил хувиарлаж, зөвлөгөө зааварчилга өгч, хяналт тавьж хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэм, бусад холбогдох журмыг мөрдүүлнэ.					
60	Техникч, механикч нь автомашины гэмтэл илрүүлэх, оношлох, засварлах, тохиргоо хийх ажлыг тусгай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглан, мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагад тулгуурлан хийнэ.					

61	Техникч, механикч нь автотээврийн хэрэгслийг засварт хүлээн авах хадгалах, сэлбэг, шатахуун тосолгооны болон ашиглалтын бусад материалын захиалга хийх, хангуулах ажил хариуцна.					
62	Засвар, үйлчилгээний засварчин нь автотээврийн мэргэжлийн сургалтын болон авто үйлчилгээний төрөлжсөн мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байна.					
63	Засвар, үйлчилгээний засварчин нь засвар, үйлчилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг бүрэн эзэмшсэн, үйлдвэрлэгчээс тогтоосон техникийн баримт бичиг, технологийн картыг судалж мэдсэн байна.					
64	Ачаа тээврийн диспетчер нь Авто тээвэрлэлтийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад чиглэн тээврийн үйл ажиллагаанд хяналт тавьж бүртгэх, авто замаар ачаа тээвэрлэх цагийн хуваарийг зохицуулах, удирдлагад тайлан бэлтгэх зэрэг ажлыг гүйцэтгэнэ.					
65	Ачаа тээврийн диспетчер нь тээврийн хэрэгсэл болон жолооч нарыг хуваарилах, ачааг ачих, буулгах, дамжин өнгөрөх барааг хадгалах зэрэг авто тээврийн ашиглалтын үйл ажиллагааг зохицуулан бүртгэл хөтөлнө.					
66	Ачаа тээврийн диспетчер нь ачаа тээвэрлэлтийн гэрээнд тусгагдсаны дагуу ажлын зохион байгуулалтыг хийнэ.					
67	Ачаа тээврийн диспетчер нь замын хуудас болон тээврийн дагалдах баримтыг уг тээвэрлүүлэгчийн ачаа ачих, буулгах ажлыг хариуцсан төлөөлөгчид өгөх ба тэр нь замын хуудас, тээврийн дагалдах баримтад ачилт, буулгалтад ирсэн болон дууссан цагийг тэмдэглэн гарын үсэг зурна. Ачааг ачсан буулгасан тухай тэмдэглэлийг холбогдох баримт бичигт бүрэн хийж баталгаажуулна					
68	Хүнд даацын автомашины жолооч нь ерөнхий боловсролын суурь болон бүрэн дунд боловсролтой, хүнд даацын автомашины жолооч бэлтгэх дамжаадүүргэсэн, жолоочийн мэргэжлийн "С", "Е" ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхтэй, мэргэшсэн жолооч, 23-аас дээш насны хүн байна.					









69	Жолоочийн мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх чиглэлээр сургалтын төлөвлөгөө гарган давтан сургах үйл ажиллагааг зохион байгуулах;					
70	Мэргэшсэн жолооч болон “С”, “D” ангиллын тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох жолооч нь тээврийн хэрэгслийн өмчлөгч эсэхээс үл хамааран жолоочийн даатгалд заавал даатгуулна.					
71	Жолоочийн ажил, амралтын горимыг хянах төхөөрөмж суурилуулсан байна.					
<b>УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮН ТЭЭВЭРЛЭХ ХҮНД ДААЦЫН АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ НЬ ДАРААХ ШААРДЛАГЫГ ХАНГАНА</b>						
72	Уул уурхайн бүтээгдэхүүн нь (нүүрс, жонш, хүдэр гм) задгай, нурмаг байдлаар, бөөнөөр их хэмжээтэй тээвэрлэгдэх учраас тээвэрлэлтийн явцад замын донсолгоо, чичиргээ, савалгаанд асгарч гоожих зэргээр хорогдож үрэгдэх, алдагдах, байгаль орчныг бохирдуулах явдлаас сайтар хамгаалагдсан байх;					
73	Ачих, буулгахад механикжсан арга, техник хэрэглэх, тээвэрлэлтэд хүлээж авах, хүлээлгэн өгөхөд жинлэх боломжоор хангагдсан байх;					
74	Уул уурхайн бүтээгдэхүүнийг автомашин, чиргүүл, хагас чиргүүлийн тэвшний дээд ирмэгээс илүү гаргахгүйгээр нуруулдаж ачих нөхцөл бүрдсэн байх;					
<b>АЮУЛТАЙ АЧАА ТЭЭВЭРЛЭЛТЭД ТАВИХ ШААРДЛАГА</b>						
75	Ачаа илгээгч нь гарч болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө, аюулгүй ажиллагааны зааврыг тус тус батлуулж тээвэрлэгч байгууллага, жолооч, дагалдан яваа хүмүүст танилцуулан гарын үсэг зуруулж гэрээнд хавсаргасан байна.					
76	Химийн бодисын хор аюулын лавлах мэдээллийн хуудас /material safety data sheet/ дагалдах баримт бичгийг үйлдвэрлэгч боловсруулж гэрээнд дагалдуулна.					
77	Даралтат сав нь техникийн паспорттай байх бөгөөд мэргэжлийн байгууллагаар баталгаажуулагдсан байна.					
78	Автотээврийн хэрэгсэл болон сав баглаа боодол дээр хор аюулын анхааруулах тэмдэг, санамжийг байрлуулж зохих зааврын дагуу тээвэрлэнэ.					



79	Химийн хорт болон аюултай бодисын тээвэрлэх, ачих, буулгах үеийн аюулгүй ажиллагааг химийн хорт болон аюултай бодисыг тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэгч хариуцна.					
80	Химийн хорт болон аюултай бодис, хог хаягдлыг тээвэрлэх маршрутыг аль болох хөдөлгөөний эрчим болон бартаа саад бага байхаар сонгож, тээвэрлэх цаг, хугацааны талаар тухайн орон нутгийн онцгой байдлын байгууллага болон замын цагдаагийн албанд мэдэгдэж, аюулгүй байдлыг хангах талаар зөвлөмж чиглэл авсан байна.					
81	Аюултай ачааг осол аюулгүй тээвэрлэх үндсэн нөхцөлийн нэг нь анхан шатны болон давтан сургалтууд байх ба тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь зохих шатны сургалтад заавал хамрагдсан байна.					
82	Жолооч нь тухайн ангилалд тохирох жолоодох эрхийн болон мэргэшсэн жолоочийн үнэмлэхтэй, аюултай ачааны чиглэлээр зохих сургалтад хамрагдсан байх;					
83	Тухайн ангиллын автотээврийн хэрэгслийг 3-аас доошгүй жил тасралтгүй жолоодож дадлагажсан байх;					
84	Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, галын аюулгүй байдлын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх;					
85	Тээвэрлэх аюултай ачааны төрөл өөрчлөгдөхөд тухай бүр тухайн ачааны тээвэрлэлтийн онцлог болон аюулгүй ажиллагааны талаарх зааварчилгатай танилцаж гарын үсэг зурсан байна.					
86	Бага хэмжээний шингэн түлшийг төмөр торхонд, шахсан хийг баллонд тээвэрлэнэ. Өргөн хэрэглээний шахсан хий /шингэрүүлсэн шатдаг хий/-г бага хэмжээ /1.5 тонноос доош/-гээр хотын дотор түгээх тээвэрлэлтийг гүйцэтгэхдээ өмнөх сарын тээвэрлэлтийн тайлан, дараа сарын тээвэрлэлтийн талаарх мэдээллийг тухайн аймаг, нийслэлийн онцгой байдлын асуудал эрхэлсэн болон замын цагдаагийн газар, хэлтэст урьдчилан хүргүүлж, хөдөлгөөний аюулгүй байдлын болон тээвэрлэлтийн нөхцөл, шаардлагыг хангаж ажиллана.					

87	Баллонтой шахсан хийг тээвэрлэхэд хоногтой, хоног нь дотроо резинэн зөөлөвчтэй хөндөл дэр мод 2-3-ыг тэвшний уртааш хөдөлгөөнгүй байрлуулж тэдгээрийн хоногонд баллоныг, тагийг нь нэг тийш харуулан ачина. Үе хооронд резинэн зөөлөвч бүхий хоёр талдаа хоногтой модон хөндлөөр жийрэглэж, дээд үеийг талдаа хоногтой хөндлөвчөөр таглана. Баллонууд холхих хөдөлгөөнгүй байх шаардлагатай;					
88	Баллоныг босоо байрлалд эргүүлэн хаалтуудыг нэг зүг рүү харуулж байрлуулан хооронд нь жийрэг тавьж ачиж болно. Баллонд жийргийн зориулалтаар баллон тавих ховил гарган хийсэн хөндлөн мод, мөн 25 мм-ээс багагүй зузаантай олсон буюу резинэн цагираг /нэг баллонд хоёр цагираг/ хэрэглэж болох бөгөөд эсвэл баллонууд өөр хоорондоо мөргөлдөхөөс сэргийлсэн бусад жийрэг хэрэглэж болно;					
89	Баллонтой хийг хэт халахаас урьдчилан сэргийлэх ба баллон ачсан тээврийн хэрэгслийн тэвшинд тостой алчуур, торхтой шатахуун, тослох материал ачихыг хориглоно;					
90	Хоосон баллонд үлдэгдэл даралт байх тул түүний тээвэрлэлт нь цэнэглэсэн баллоныг тээх бүх шаардлагыг хангасан байна.					
91	Хүчил, шүлт зэрэг идэмхий шингэнийг үйлдвэрлэгчээс савласан зориулалтын тусгай шилэн саванд тээвэрлэнэ. Шилэн сав нь гадуураа модон хайрцаг, гөрмөл шээжгий, давхар савтай байна. Автотээврийн хэрэгслийн тэвшинд шилэн савны хоолой /таг/-г дээш харуулж босоогоор хөдөлгөөнгүй байхаар бэхэлж ачина.					
92	Аюулын зэрэг өндөр химийн хорт болон аюултай бодис бүхий ачааг зөвхөн өдрийн цагаар ачиж буулгах ба түүний ачааны тэмдэгтэд заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээг хатуу сахина.					
93	Аюултай ачаа тээвэрлэх жолооч нь /цуваагаар тээвэрлэх үед цувааны ахлагч нь/ замын хөдөлгөөний эрчим, автотээврийн хэрэгслийн онцлог байдал, тээж яваа ачаа, замын болон цаг агаарын нөхцөл, хөдөлгөөний дагуу үзэгдлийг харгалзан автомашины хурд болон хоорондын зайг замын хөдөлгөөний дүрэм, аюултай ачааны					

	стандартаар тогтоосон хязгаараас хэтрүүлэхгүйгээр сонгон өдрийн цагт ойрын гэрлээ асааж явна.					
94	Аюултай ачааг нэгэн зэрэг 3 буюу түүнээс дээш автомашинаар цуваагаар тээвэрлэх үед дараах шаардлагыг биелүүлнэ	✓	✓			
95	Тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хариуцахаар томилогдсон ажилтан /цувааны ахлагч/ цувааг зохион байгуулж, зөвшөөрөгдсөн маршрутын дагуу замын хөдөлгөөний дүрэм, аюултай ачааны стандарт, аюулгүй ажиллагааны зааврыг баримтлан аюултай ачааг тээвэрлэх үйл ажиллагааг удирдана;	✓	✓			
96	Цувааны ахлагч цувааны эхний автомашинд явах бөгөөд цувааны эхэнд хамгаалалтын автомашин, төгсгөлд нөөц автомашин явна;	✓	✓			
97	Цувааны эхний болон сүүлчийн автомашин "цуваа" гэсэн тод бичлэгтэй байх ба цуваанд эзлэх дугаарыг автомашин бүрийн урд болон ард талд харагдахуйцаар жигд байрлуулна.	✓	✓			
98	Аюултай ачаа тээвэрлэсэн автотээврийн хэрэгслийг сайтар цэвэрлэж, хоргүйжүүлнэ.	✓	✓			
99	Тээвэрлүүлэгчээс тээвэрлэлтэд бэлтгэсэн аюултай ачаа нь зориулалтын сав, баглаа боодолтой, стандартын шаардлага хангасан англи эсвэл монгол хэл дээр үйлдэгдсэн хаяг, шошготой байна.	✓	✓			
100	Тээвэрлүүлэгч нь үйлдвэрлэгчээс гаргасан хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн аюултай ачаа нэг бүрээр боловсруулсан аюулгүй ажиллагааны зааварчилгааг байгаль орчны болон гамшгаас урьдчилан сэргийлэх хяналтын улсын байцаагчаар хянуулж, баталгаажуулсан байна.	✓	✓			
101	Тээвэрлэгч, тээвэрлүүлэгч нь тухайн аймаг, нийслэлийн онцгой байдлын асуудал эрхэлсэн газар, хэлтсээр аюултай ачааг ачиж, буулгах, тээвэрлэх үйл ажиллагаатай холбоотойгоор гарч болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө боловсруулж батлуулсан байхаас гадна аюултай ачаатай автотээврийн хэрэгслийг хадгалах байр, талбай, зогсоолын аюулгүй ажиллагааны талаарх дүгнэлт гаргуулсан байна.	✓	✓			

102	Тээвэрлэгч нь аюултай ачааны тээвэрлэлтийг зөвхөн аюултай ачаа тээвэрлэх чиглэлээр мэргэшсэн жолоочоор гүйцэтгүүлэх бөгөөд ийм ачаатай автотээврийн хэрэгслийг хот, суурин газарт зориулалтын бус гараж, зогсоолд тавихыг хориглоно.					
103	Тээвэрлэгч, тээвэрлүүлэгч нь аюултай ачааг ачиж, буулгах, тээвэрлэхтэй холбогдсон аргачлал, арга зүйн чиглэлийн сургалтад ажиллагсдыг тогтмол хамруулна.					
104	Тээвэрлэгч, тээвэрлүүлэгч нь тээвэрлэлтийн явцад болзошгүй аюул учирсан тохиолдолд хэрэглэх, хор уршгийг арилгах зориулалтын багаж, хэрэгсэл /галын хор, хүрз, лоом, сүх, шуудайтай элс, хувин г.м/, хор саармагжуулах бодис, уусмал, арьс болон амьсгал хамгаалах зориулалт бүхий стандартын шаардлага хангасан хүн нэг бүрийн хамгаалалтын хэрэгсэл зэргээр автотээврийн хэрэгсэл бүрийг хангасан байна.					
105	Тээвэрлэгч, тээвэрлүүлэгч нь аюултай ачаа тээвэрлэлттэй холбогдсон мэдээллийн цахим сан үүсгэж, тухай бүр шинэчилж, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангана.					

Үнэлгээ хийсэн:

/

/

Жич: Та баталгаажуулалтын схемийн шаардлагын санал, хүсэлт, гомдлоо [certification@transdep.mn](mailto:certification@transdep.mn) цахим хаяг болон 70070017 утсаар өгч болно.